



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/09

Мандалговь

Зөвлөл орон тооны бус байнгын  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 269 дүгээр тогтоолын хавсралт “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, 4 дүгээр зүйл, Хөдөлмөрийн сайдын 2015 оны “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” А/114 дүгээр тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3, 2.4, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа, төсөл хөтөлбөр, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2.Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах зам (ажлын байр, ажилтай холбоотой сургалтад оролцож байгаа, түр болон байнга оршин суудаг газар, голлон хооллодог газрын хооронд)-даа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, явган явах маршрутыг батлуулж албан хаагчдад танилцуулахыг комиссын даргад даалгасугай.

3.Батлагдсан зам маршрутыг мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад зөвлөсүгэй.

4.Хууль, дүрэм, журам холбогдох бичиг баримтын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА

